

2022 оны 2 дугаар улиралын санхүүгийн

үйл ажиллагааны товч тайлан

Чойбалсан хот

2022,07,31

“Дорнод Авто зам” Хувьцаат компани нь аймгийнхаа нутаг дэвсгэрт байгаа улсын чанартай асфальт бетон хучилттай 160 км зам, ердийн хөрсөн 819,92 км зам, хайрган хучилттай 291,17 км зам, сайжруулсан хөрсөн 13,66 км зам нийт 1284.75км авто замын арчлалтын хариуцан гүйцэтгэдэг бөгөөд эдгээр замууд нь ОХУ,БНХАУ-тай 7 чиглэлээр холбогддог, улс хоорондын авто замын тээвэрт чухал үүрэг ач холбогдолтой. Халхгол, Хэрлэнгийн доод дээд 2 гүүр,Улзын голын нийт 4 бетон хийц бүхий 864 у/м гүүрүүдийн арчлалт хамгаалалтын ажлыг 4 гүүр хамгаалагч хариуцан ажиллаж байна.

Манай компани нь 2022 оны 2-р байдлаар 222,5 сая төгрөгийн борлуулалтын орлого олж, 221,5 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан. 2022 онд Зам,Тээврийн Хөгжлийн Яамтай хийсэн гэрээний дагуу улсын чанартай зам засвар арчлалтын болон бусад гэрээний дагуу ажлууд хийж гүйцэтгэж байна. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, ажлыг гэрээт хугацаандаа бүрэн хийж гүйцэтгэх, техникийн бүрэн бүтэн байдал,сэлбэг шатахуун,материалаар тасралтгүй ханган ажиллах , ажлыг жигд явуулахын тулд график төлөвлөгөө гарган, цаг тухайд нь гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна. Авто зам, замын байгууламжийн урсгал засвар,арчлалтын ажлыг холбогдох норм,дүрэм,стандарт, журмыг баримтлан, гэрээнд болон график төлөвлөгөөнд заасан хугацаа, хөрөнгийн хэмжээнд багтаан техникийн шаардлагын дагуу гүйцэтгэж,авто зам,замын байгууламжийн байнгын бэлэн байдлыг ханган ажиллахад анхааран ажиллаж байна.

Компани оны эхний 6 сарын байдлаар 29 ажиллагсадтайгаар зам засвар арчлалтын ажилд ажиллаж, цалингийн зардалд 111,7 сая төгрөг, НДШимтгэлд 15,6 сая төгрөг , материал түүхий эд худалдан авах, сэлбэг хэрэгсэл болон шатахууны зэрэг шууд үйлдвэрлэлийн зардалд 94,2 сая гаруй сая төгрөгийг зарцуулав. Татвар шимтгэлд 10,2 сая төгрөгийн татвар төлөлтийг аймаг орон нутгийн татварт төвлөрүүлөн ажиллалаа.

Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг НББОУС-ын дагуу хөтлөн, баланс,орлого үр дүнгийн тайлан,өмчийн өөрчлөлтийн тайлан,мөнгөн гүйлгээний тайлан,бусад тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланг бэлтгэн компанийн удирдлагыг санхүүгийн иж бүрэн мэдээлэлээр ханган ажиллаж байна.

Тайлан бичсэн:

“Дорнод Авто зам” Хувьцаат компанийн

Нягтлан бодогч



Ц.ОТГОН